



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨГҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 01 сарын 06 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг
шинэчлэн батлах тухай

“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсэг, “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Удирдлагын багийг даргын зөвлөл гэж өөрчилсүгэй.

2. “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, даргын зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний загварыг гуравдугаар хавсралтаар, хуралдааны тэмдэглэлээс загварыг дөрөвдүгээр хавсралтаар, хуралдааны шийдвэрийн загварыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн A/01 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Даргын зөвлөлийн ажиллах журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Нягтлан бодогч /Г.Батням/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Б.Алтан-Очир/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ

3150600015